



Онгорсон долоо хоногт Горний Алтайн Улсын их сургууль дээр тус сургуулийн захирал Валерий Бабин, АБНУ-ын Сэтгүүлчдийн холбооны дарга Борис Алушкин, Сэтгүүлчдийн холбооны дэд дарга, долоо хоног тутмын “Вестник Горно -“Алтайска” сонины еронхий редактор Алексей Ивашкин нарын албаны хүмүүс уулзалдав.

Уулзалтанд оролцогсад 1966 онд Манжерокд болж онгорсон Зовлолт Монголын залуучууд, оюутны анхдугаар их наадмын тавин жилийн ойн бэлтгэл ажлын талаар ярилцсан байна. Уулзалтын үр дүнд уг наадмыг зохион байгуулахад Алтайн их сургуулиас санхүүгийн дэмжлэг эзүүлэх тодорхой зардлуудыг хариуцахаар шийдвэрлэсний зэрэгцээ наадмын сүүлчээр 2016 оны 9 сарын 27-ны одор Улсын думын депутатуудыг Майманскийн районы Манжерок суурин дахь аяллын баазад зочлуулахаар хэлэлцэж тохирсон байна.

Энэ үеэр дэлхийн аялал жуулчлалын одорт зориулсан арга хэмжээнүүд явагдах юм байна. Уг арга хэмжээнд Алтайн их сургуулийн толоологчид, оюутнууд мон Монголын Үндэсний их сургууль, Ховд их сургуулийн толоологчид, оюутнууд болон анхдугаар их наадамд оролцож байсан ахмадууд оролцох нь эргэлзээгүй юм байна. Тэрчлэн наадмын зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнд Монголын талаас ажиллаж буй Үндэсний их сургуулийн профессор Наваанзоч Х.Цэдэв, Ховдын толь сонины еронхий редактор Гонгоржавын Тормонх нарын хүмүүс дээрх бүх үйл ажиллагаанд оролцож, хамтран зохион байгуулах юм байна. Монголын Баян-Олгий аймгаас оюутнууд болон багш нар уг наадамд оролцох хүсэлтээ илэрхийлээд байгаа гэнэ.

1966 оны 8 дугаар сард болсон анхдугаар наадмыг ЗХУ-ын Бvх холбоотын Лениний коммунист Залуучуудын холбооноос санаачилж, Манжерок сууринд зохион байгуулсан тvvхтэй. Тэнд Оросын алдарт дуучин Эдита Пьеха, “Цэцгийн баглаа” циркийн акробатчин Геннадий Попов, Зовлолтийн нэрт кино жvжигчин Сергей болон Крилл Столяров, АА бусад алдартай жvжигчид тэрчлэн яруу найрагчид, хогжмийн зохиолчид оролцож байжээ.

Тэр veийн Монголоос буюу БНМАУ-аас тамирчид, балетийн жvжигчид, мэргэн харваачид, тэргvvний ажилтан,АА ажилчид, сэтгvvлчид очиж оролцсон байна. “Оноодор бид тэр вйл явдлыг тун энгийн даруухан хэрнээ нийтийг хамруулан тэмдэглэж, тухайн цаг veийнхээ нандин сайхан бvхнийг дуудан сэрээхэд гол ач холбогдлыг чиглvvлж байгаа юм. Хамгийн чухал нь гэвэл залуучуудын эх оронч хvmvvжил, цэвэр ариун ёс суртахууныг эрхэмлэж, тvvнийг хоногшуулан толовшvvлэх явдал” юм хэмээн зохион байгуулагчид vгvvлж байна. .

Дмитрий Соколов